



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/190

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 1.2, дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөө батлах тухай" 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх 1 нэгж талбар газрын анхны үнэ, хэмжээ байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Дуудлага худалдаа явуулах тухай зарыг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж, холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээн авч дуудлага худалдааг зохион байгуулахыг газрын даамал (С.Аравзайлхам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2024 оны 09
дугаар сарын 27-ны өдрийн захирамжийн хавсралт

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ,
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх Зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ (төг)
	1	2	3	4	5
1.	Бат-Өлзий сумын 4 дүгээр баг, багийн төвийн хойно	3897166	2117: Шатахуун түгээх газар, агуулах	2000	1,600,000.0

---000---